

## Их, дээд сургуулиудад либерал артс боловсрол олгох хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх асуудалд (философийн хичээлийн жишээн дээр)

И.Лхам, Г.Уянга \*

ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургууль, Хөдөө аж ахуйн хэрэглээний тэнхим

### Хураангуй

XX зууны 90-ээд оноос Монголын дээд боловсролын системийн шинэчлэх ажил хийгдэж байна. Энэ хүрээнд өнөө үед философийн боловсролын шинэчлэл, тэр дундаа их дээд сургуульд заагдаж буй уг хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгох ажил өрнөж байна. Философи бол ертөнц, түүнд орших хүний ахуйг рациональ байдлаар танин мэдэхэд чиглэсэн сэтгэхүйн, онолын, танин мэдэхүйн онцгой хэлбэр юм. Философийг судлах нь ардчилсан нийгэм дэх иргэн хүнд зайлшгүй шаардлагатай шинж болох шүүмжлэлт болон бүтээлч сэтгэхүйг хөгжүүлдгээрээ ач холбогдолтой.

Энэхүү өгүүлэлд их дээд сургуулиудад философийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх асуудлыг олон талаас нь авч үзсэн бөгөөд ялангуяа заах арга зүйн асуудалд илүү анхаарав. Зохиогчид их дээд сургуулийн багш нарт тулгарч байгаа асуудалд уншигчдын анхаарлыг хандуулахыг зорьсон. Хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх гэдэг нь лекц, семинарын хөтөлбөрийг уламжлалт байдлаар бус илүү шинэлэг арга зүйгээр хэрхэн зохион байгуулах вэ? гэдэг асуудал юм. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ философийг заахад тулгарч байгаа үндсэн гурван асуудалд буюу Юу заах, Яаж заах, Яагаад зааж байгаа вэ? гэдэгт хариулт өгөхийг оролдлоо.

### Түлхүүр үг

Либерал артс, шүүмжлэлт болон бүтээлч сэтгэлгээ, прагматик хандлага.

### Удиртгал

Дэлхий дахинаа нийгэм-эдийн засгийн хөгжлийг хувь хүний хөгжлөөр хэмжиж буй үед Монгол Улсад “хүнийг хөгжүүлэхэд” чиглэсэн «liberal arts» (либерал артс)-ын тодотголтой хичээлүүдийн үнэ цэн, ач холбогдлыг онцгойлон анхаарах болсон нь сайшаалтай юм. Мэргэжлийн гэхээсээ илүүтэйгээр ерөнхий мэдлэг олгож, суралцагчдын оюуны царыг тэлэх шинжлэх ухааныг Либерал арт гэнэ<sup>1</sup>. Либерал арт нь нарийн мэргэжлээс илүүтэйгээр хувь хүнийг төлөвшүүлэхэд анхаардаг. “liberal arts” боловсрол нь ямар нэг мэдлэг эзэмшүүлэх сургалт бус, харин мэдлэгийг оюун ухаандаа боловсруулах үйл явц, шинэ санааг урлах чадвар, дадал эзэмшүүлэх сургалт гэж тайлж болох юм» (Орхон, 2013, хууд. 2). Алберт Эйнштэйний<sup>2</sup> хэлсэнчлэн «Либерал артсын боловсролын үнэ цэн нь баримт нотолгоог суралцахад бус, харин сурах бичгээс сурдаггүй зүйлийг чөлөөтэй сэтгэж сурахад оршино». Либерал артад нийгмийн ухаан (түүх, сэтгэл судлал, улс төр судлал, эдийн засгийн ухаан, хууль, жэндер судлал, антропологи, социологи), байгалийн ухаан (физик, хими, биологи, геологи, амьтан судлал, археологи, ургамал судлал,

астрономи), хүмүүнлэгийн ухаан (философи, ёс зүй, шашин судлал, урлаг, хэл шинжлэл, уран зохиол), формал ухаан (математик, логик, статистик) багтдаг. Либерал артсын боловсролын зорилго нь суралцагч авьяасаа нээж, ур чадвар эзэмшсэнээр цаашид өсөн дэвжихэд нь туслах явдал юм.

Либерал артсын боловсролыг чухалчилж буй өнөө үед бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээтэй, бие даан бодож эргэцүүлдэг, асуудалд олон талаас нь хандах замаар оновчтой шийдвэр гаргаж чаддаг, хамтын ажиллагаа-шийдвэрийг хүндэтгэдэг, идэвхтэй, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг болох нэг чухал хичээл нь философийн хичээл юм. Тиймээс энэхүү хичээлийн агуулгыг оновчтой тодорхойлж, түүнд тохирсон сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх нь багш бид бүхний үүрэг билээ.

Энэхүү өгүүлэлд их, дээд сургуулийн сургалт дахь «философийн хичээл»<sup>3</sup>-ийг мэргэжлийн бус ангид заахад агуулга, ашиглаж болох сургалтын зарим идэвхтэй аргыг танилцуулах зорилго тавьж, өөрсдийн туршлагад тулгуурлан дараах саналуудыг дэвшүүлж байна.

\* ✉ uyangaa@mul.s.edu.mn

1 Richard Sigurdson. Why study the Liberal Arts? <http://www.uni.edu/reineke/whystudyla.htm>, p.1.

2 Albert Einstein

3 БШУ-ны сайдын “Хичээлийн жагсаалт батлах тухай” А/285 тоот тушаалаар (2014) “Сэтгэлгээний түүх, соёл” гэж нэрлэх болсон.

## Судалгааны хэсэг

Философи бол хүн төрөлхтний хамгийн анхны бөгөөд арвин өв сантай мэдлэгийн салбар юм. Философийг судлах, философийн мэдлэгийг өсгөн арвижуулах нь тухайн хувь хүний болоод нийгмийн хувьд ач холбогдолтой байдаг. Тухайлбал, философи нь хүний бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээгээ хөгжүүлж, үзэгдэл, үйл явдалд илүү өргөн хүрээнд харах, ухаалаг үндэслэгээ дэвшүүлэх чадвар зэрэгт суралцуулдаг бол нийгмийн амьдралд үзэл санааны хувьд хүчтэй нөлөө үзүүлж чаддаг. “Орчин үеийн боловсролын философийн эцэг” хэмээгч Ж.Дьюи<sup>4</sup> «Философид реконструкци хийх нь» хэмээх бүтээлдээ философийг хэрхэн ойлгож, хэрэглэх талаарх асуудлыг авч үзжээ. Тэрээр уг бүтээлдээ «Философийн агуулга юунд байдаг вэ? гэдгийг юуны түрүүнд ойлгох нь зүйтэй. Философи бол хүний үйл ажиллагаа дахь оюуны болон ёс суртахууны үндсийг илрүүлэхэд чиглэсэн мэдлэгийн салбар мөн. Энэ үүргийнхээ үүднээс философи нь өнөөгийн нийгмийн зөрчил болон ялгааг гаргаж, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэх нэг арга зам нь болж чадна. Философи бол гүн бясалгал төдийхөн биш, харин нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэл юм. Тиймээс философийг «оюун ухааны гимнастик» хэмээн үзэж, үгэн шинжилгээ төдийхөн хийдэг хэмээн ойлгохоос татгалзах хэрэгтэй» хэмээн бичжээ (Лхам, Уянга, 2018, хууд. 53).

Манай салбарын туршлагатай эрдэмтэн багш нарын хувьд ч хүний хөгжилд философийн боловсролын үүрэг, нөлөөг онцгойлон тэмдэглэж ирсэн. Тухайлбал, доктор А.Энхбаатар “Их, дээд сургуульд суралцаж олж буй мэдлэг, чадвараас хүнийг насан туршид нь дагах боловсрол бол философийн боловсрол юм” (Энхбаатар, 1998, хууд. 28) гэсэнтэй санал нэг байна.

### Философийн хичээлийн агуулгын асуудалд

Хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлийн нэг асуудал нь хичээлийн агуулгын өөрчлөлт юм. Философийн хичээлийн агуулгыг шинэчлэх, сайжруулах чиглэлээр 2000 онд холбогдох 32 байгууллагын 85 албан тушаалтан, багш, эрдэм шинжилгээний ажилтан оролцсон семинараас тус хичээлийн агуулгыг «Философи гэж юу болох, онтологи, танин мэдэхүйн онол, методологи, ёс зүй, гоо зүй, хүний тухай философи, шашны тухай философи, нийгмийн философи» хэмээн санал болгож, үлдсэн цагт нь сургууль өөрийн онцлогтоо нийцүүлэн салбар философийн агуулга

нэмж болохыг дэмжсэн юм. Тиймээс энэхүү шийдвэрийг баримтлан ажиллах нь арга зүйн хувьд зүйтэй юм.

Энэхүү хичээлийн агуулга өнөөгийн нөхцөлд зарим их сургуулиудын хувьд ямар байгааг авч үзье. (\*) тэмдэглэгээ нь тухайн сэдвийг 2 цаг, (\*\*) нь 4 цагаар судлуулж буйг илэрхийлж байгаа болно. Зөвхөн семинарын хичээлийн агуулгад багтсан сэдвүүдийг (+) гэж тэмдэглэв.

### Хүснэгт 1

Философийн хичээлийн агуулгын харьцуулалт

| Сэдвүүд                       | МУИС   | ХААИС <sup>5</sup> | СУИС <sup>6</sup> | АШУУИС | УБХИС |
|-------------------------------|--------|--------------------|-------------------|--------|-------|
| Удиртгал                      | *      | *                  | *                 | *      | *     |
| Философи сэтгэлгээний түүх    | **     | *                  | ****              | ++++   |       |
| Онтологи, метафизик           | *      | *                  | *                 | **     | ***   |
| Экологийн философи            |        | *                  | *                 |        | *     |
| Хүний тухай философи          | **     | **                 | *                 | *      | *     |
| Танин мэдэхүйн онол           | **     | **                 | **                | **     | **    |
| Логик                         | *      | *                  | *                 | **     | **    |
| Нийгмийн, улс төрийн философи | **     | *                  | *                 | *      | **    |
| Ёс зүйн философи              | **     | **                 | *                 | **     |       |
| Үнэлэмжийн философи           | *      | *                  | *                 | ++     | *     |
| Соёлын философи               | *      | *                  |                   |        | *     |
| Урлагийн философи             |        | *                  |                   |        |       |
| Шашны тухай философи          | *      | *                  | *                 | *      | *     |
| Монголын философи сэтгэлгээ   |        |                    | *                 | +      | *     |
| цаг                           | 32 цаг | 32                 | 32                | 24     | 32    |

Эх сурвалж: Дээрх нэр бүхий сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүд

Эндээс үзэхэд “Удиртгал, онтологи метафизик, логик, шашны тухай философи, урлагийн философи” сэдвийг тус бүрд нь 2 цагаар, харин “хүний тухай философи, эпистемологи, ёс зүй” зэрэг сэдвийг тус бүр нь 4 цагаар, мөн “философийн түүх”-ийг 2-10 цагаар буюу харилцан адилгүй агуулгаар зааж байна. Түүнчлэн сургуулийн онцлогоос хамаарч зарим сэдвийг

5 Лекц, семинарын сэдэв адилхан

6 Лекц, семинарын сэдэв адилхан

4 Dewey, J.

нэмж, заримыг нь хасаж зааж байна<sup>7</sup>. Хичээлийн агуулгыг томъёолохдоо бид “мэргэжлийн бус ангийн оюутанд зориулан энэхүү хөтөлбөрийг боловсруулж байгаа” гэдгээ санаж, “бүгдийг” тусгана гэсэн байр сууринаас татгалзах хэрэгтэй болов уу?.

Философийн хичээлийн заах арга зүйг боловсронгуй болгох нь

Хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлд тухайн хичээлийг заах арга зүйн асуудал чухал байр эзэлнэ. Манай их, дээд сургуулиудад философийн хичээлийг үр өгөөжтэй заах асуудлаар судалгааны цөөн тооны өгүүлэл хэвлэгдсэнээс профессор Ц.Гомбосүрэн, академич Г.Чулуунбаатар, доктор Т.Нэмэхжаргал нарын өгүүллийг энд онцлон дурдаж байна.

Профессор Ц.Гомбосүрэн нь манай улсын философийн сургалтын шинэчлэлийн ажлыг санаачлагч, хэрэгжүүлэгчдийн нэг юм. Тэрээр философийн сургалтад арга зүйн олон ургалч үзлийг нэвтрүүлэх шаардлага буйг 1990 оноос эхлэн тавьж байсны үр дүнд энэ чиглэлээр багагүй шинэчлэлийн ажил хийгдсэн. Академич Г.Чулуунбаатар «Философийн сургалт, судалгаанд этнометодологийн арга зүйг хэрэглэх» (Чулуунбаатар, 1998, хууд. 58)-ийн ач холбогдлын талаар мөн онцолсон байдаг.

Хичээлийн агуулгыг хэрхэн ойлгомжтой бас сонирхолтой байдлаар хүргэх вэ? гэдэг асуулт бол боловсролын салбарын мөнхийн асуудлын нэг билээ. Өнөө үед тухайн хичээлд холбогдох бүх агуулгыг ээлж дараалан цээжлүүлэн сургахаас илүүтэй хичээлийн тодорхой агуулгыг оюутнуудын суралцаж буй мэргэжил, сонирхол, хэрэгцээнд тулгуурлан тодорхойлох хандлага хүчтэй болжээ. Ингэхдээ аль болох оюутныг өөрийг нь оролцуулах, өөрөөр нь үйлдүүлэх арга зүйг чухалчлах болов. Энэ хүрээнд боловсролын аль ч түвшинд мэдлэг бүтээх конструктив онол, прагматик хандлагыг хэрэгжүүлэхийг дэмжиж байна.

Философийн хичээлийн хувьд дээрх онол, хандлагыг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой хичээлийн нэг бөгөөд ингэснээр «философи уйтгартай», «философид шийдэгдсэн зүйл нэг ч байдаггүй», «философийг үзсэнээр амьдрал утга учиргүй болдог», «философи бол зөвхөн онолын дээд мэдлэг тул амьдралд хэрэглэгддэггүй» гэх мэт шүүмжлэлээс зайлсхийж чадах юм.

Бид сүүлийн 6 жилийн ажиглалт, туршлагадаа тулгуурлан дээд боловсрол дахь сэтгэлгээ

хөгжүүлэх хамгийн үр ашигтай хичээлийн нэг нь философийн хичээл хэмээн дүгнэж байна. Философийн хичээлийн зорилго нь «оюутнуудад философийн түүх болон онолын мэдлэг олгох, сэтгэн бодох, ухааран ойлгох болон практик үйл ажиллагаандаа ашигладаг чадвар олгоход оршино (Их, дээд сургуулиудад зааж буй философийн хичээлийн агуулга, бүтцийн шинэчлэлтийн зарим асуудал, 2000).

Бидний үзэж буйгаар «Семинарын хичээл бол бүхэлдээ диалогит суурилсан, суралцагчдын оролцоог хангасан, эрэл хайгуул, судалгаа шинжилгээ байх ёстой» (Насанбат, Уянга, 2016, хууд. 175). Семинарын хичээл дээр үргэлж нэг аргаар ажиллах бус, харин суралцагчдын танин мэдэхүйн сонирхол, хэрэгцээг харгалзаж, оюун ухаан, мэдрэмж, хүслийг цогц хөгжүүлэхэд идэвхтэй өөр өөр арга ашиглах нь үр дүнтэй байдаг. Хүн хийснийхээ хэмжээгээр сурдаг тул хичээлдээ аль болох “үйлдүүлэх”-д анхаарч, багаар ажиллах, харилцан суралцах бүх бололцоог хангаж өгөх шаардлагатай юм.

Философийн хичээлээр өргөн хүрээнд сэтгэх, асуудлыг олон талаас нь харж шийдвэрлэх, өөрийн үзэл бодлыг шүүн хэлэлцэх, тунгаах, илэрхийлэх, дэвшүүлсэн санаагаа хамгаалах чадварт оюутнуудыг сургах нь чухал юм. Эдгээр чадварт ганцаарчлан болон багаар үр бүтээлтэй ажиллах, бие даан ажиллах замаар суралцдаг тул зарим даалгаврыг нь ганцаараа, заримыг нь багаар хийх, бас бие даан ажиллах даалгавруудыг санал болгох нь чухал. Өөрөөр хэлбэл, даалгавруудыг оюутнуудад сонголттойгоор өгөх, биечилсэн оролцоо, эрэл хайгуул, сэтгэн бодохуйг чухалчилдаг прагматик хандлагыг эрхэмлэх нь илүү үр дүнтэй юм.

Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд «орчин үеийн боловсролын философийн эцэг» Ж.Дьюи «Миний сурган хүмүүжүүлэх үзэл», «Туршлага ба боловсрол», «Боловсрол дахь ёс суртахууны зарчим» зэрэг бүтээлдээ сургалтын аргын талаар авч үзсэн байдаг. Тэрээр «Уламжлалт сургалтын аргын дутагдалтай талыг засаж, дэвшилтэт боловсролын сургалтын аргыг боловсруулсан» (Дьюи, 1938, хууд. 19). Ж.Дьюи “Сургалтын арга нь ардчилсан, чөлөөт зарчимд тулгуурлах ёстой бөгөөд амьдралтай холбогдсон байх нь чухал” (Дьюи, 1897, хууд. 13) хэмээн үзжээ. Тэрээр ийм сургалтын аргад сорилт туршилтын, диалоги, тоглоомын, драмын болон урлагийн бие даасан үйл ажиллагаа, аяллын, төслийн арга зэргийн олон талын ач холбогдлыг онцолсон байна. Эдгээр аргуудыг философийн хичээлд ашиглах бүрэн боломжтой.

<sup>7</sup> Тухайлбал, ХААИС нь өөрийн сургалтын онцлогт тааруулан “Экологийн философи” сэдвийг нэмсэн бол СУИС нь “Гоо зүй” гэсэн хичээлийг үздэг тул “Урлагийн философи” сэдвийг хассан байна.

Философийн хичээлээр суралцагчдын сонирхол, сэдлийг хөгжүүлж, суралцагчдад шүүмжлэлт сэтгэлгээ, өдөр тутмын амьдралынхаа янз бүрийн асуудлыг тодорхойлох, боловсруулах, шийдвэрлэх, асуудалт нөхцөл байдалд ажиллах чадварыг төлөвшүүлэх, бие даасан эрэл хайгуул хийлгэх замаар мэдлэг олгох явдал нь нэн тэргүүний зорилт байна. Энэ бүхэнтэй уялдуулж философийн хичээл дээр дараах зүйлсийг хийлгэх боломжтой. Үүнд:

#### Хүснэгт 1

Семинарын хичээлд ашиглаж болох дасгал ажлууд

| Даалгаврын нэр                    | Хэрхэн хэрэгжүүлэх-жишээ                                                                                                                                             |
|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өөртөө захиа бичих                | Өөрийн намтрыг бус, харин өөрийгөө шүүн шинжилж, өөртөө хандаж даалгаврыг хийнэ.                                                                                     |
| “Би” илтгэл тавих                 |                                                                                                                                                                      |
| Кино хэлэлцүүлэг                  | Эпистемологи, хүний тухай философи зэрэг аль ч сэдэв дээр тохирно. Киног оновчтой сонгох нь чухал.                                                                   |
| Фото хэлэлцүүлэг                  | Хүний ахуйн үзэгдлүүдийг тайлбарласан фото зургийг авч, утга санааг тайлбарлана. Бусад нь шүүн хэлэлцэнэ.                                                            |
| Би хэн бэ? багийн ажил зохиох     | I үед философичдыг, II үед философийн нэр томъёог, III үед философи сэтгэлгээний аль үе шатанд буйг олж тогтооно.                                                    |
| Нэвтрүүлэг зохиох                 | Центавр, Үсэглэлийн хаад, Тататунгаа, 50 саяын уналт зэрэг нэвтрүүлгийг философийн агуулгын хүрээнд зохиох нь үзсэн зүйлээ бататгах, сэргээн санах, давтахад тустай. |
| Захидал илгээх                    | “Экологийн философи”-ийн семинар дээр эко уран зохиолын төрлөөр амьтад хүн төрөлхтөнд хандан бичиж байгаагаар төсөөлөн захидал бичнэ.                                |
| Мэтгэлцээн зохиох                 | Тодорхой нэг үзэл санааг зөвтгөх, няцаахад чиглэнэ. Ёс зүйн нээлттэй асуудлаар хийвэл сонирхолтой болдог.                                                            |
| “Хорогдох байр” сэтгэхүйн туршилт | Өөрийгөө “хэрэгтэй хүн” болохыг бусдад зөв ойлгуулж, бусдыг сонсож, сонголт хийж, шийдвэр гаргах болно.                                                              |
| Шүүх хурал хийх                   | Өөрийн үйлчлүүлэгчийн буруугүй байж болох хамгийн бодитой үндэслэгээг боловсруулж, түүнийгээ хамгаална.                                                              |
| Хэрвээ? илтгэл                    | “Хэрвээ би ... философич байсан бол ... асуудлаар ... гэж хэлэх байсан” гэсэн агуулгаар уг даалгаврыг гүйцэтгэнэ.                                                    |
| Толь бичиг зохиох                 | Философийн урсгал чиглэлүүд, гол төлөөлөгчдийг багтаасан мини толь бичиг хийлгэнэ.                                                                                   |
| Үгийн сүлжээ зохиох               | “Миний мэдэх философи” сэдвийн хүрээнд үгийн сүлжээ зохионо. Ашигласан материалыг заавал дурдуулах шаардлагатай.                                                     |
| Хамтын эсээ бичих                 | Эхний гишүүний бичсэнийг дараагийн гишүүн үргэлжлүүлэх замаар философийн тодорхой асуудлаар багаараа эсээ бичнэ.                                                     |

|                         |                                                                                                                                                                                   |
|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Кейс шинжлэх            | Ёс зүйн асуудлыг ялган таних, зохистой шийдвэрлэх ямар боломж буйг тодорхойлох зорилгоор кейс судалгаа хийлгэнэ.                                                                  |
| Тараах материал бэлтгэх | Нийгэм улс төр, урлагийн философи зэрэг сэдвээр тодорхой нэг чиглэлийг танилцуулсан тараах материал бэлтгэж, танилцуулна.                                                         |
| Тест зохиох             | Аль ч сэдвээр хийлгэх боломжтой. Гол нь тестүүд нь энгийн, хүнд, хүндэвтэр гэх мэтээр хөнгөнөөс хүнд рүү шилжсэн агуулгатай байхыг сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй байдаг.        |
| Эх зохиол судлах        | Монгол хэл дээр орчуулагдсан философийн эх зохиолоос уншуулах, гол санааг ойлгосноо бичиж тэмдэглэх. Дараа нь өөрийн ойлгосон зүйл, олж авсан санаагаа хамгаалах ярилцлага хийнэ. |

Эх сурвалж: И.Лхам, Г.Уянга нар.(2018) .“Бүтээлч сэтгэхүй” сэтгэлгээний түүх, соёл хичээлийн гарын авлага Улаанбаатар

Эдгээр дасгал ажлууд нь философийн, бүр тодруулбал хүний амьдралд тулгамдсан тодорхой асуудлыг шийдэхэд чиглэж байдгаараа онцлог юм. Түүнчлэн дээрх даалгавруудыг сонголттой хийлгэх, жижиг багаар гүйцэтгүүлэх, хэлэлцүүлэх, бичүүлэх, бүтээлгэх, биечлэн үйлдүүлэх зэргээр өөр өөр арга замаар хэрэгжүүлэх бололцоог мөн олгох шаардлагатай. Боловсролын тухай прагматик үзэлд дээрх арга барилыг ардчилсан шинжтэй сургалтын арга хэмээдэг бөгөөд энэ нь хүний амьдрал дахь бодит оролцоо, түүнээс гарах дээд зэргийн хүмүүнлэгийн ач холбогдлыг илрүүлэхэд чиглэдэг бөгөөд хувь хүний онцлогийг нээн хөгжүүлэх боломжийг агуулж байдаг. Тийм ч учраас «Ардчилсан арга барил үгүй бол сургалтын үйл явцын олон дутагдал үүнээс үүдэн бий болно. Учир нь суралцагч сургалтын явцад шинэ мэдлэгт суралцахаас гадна хүмүүжих ёстой» (Дьюи, 2003, хууд. 179) хэмээн үзэнтэй санал нийлж байна. Өөрөөр хэлбэл, багш сургалтын аргыг хэрэгжүүлэхдээ хүмүүжүүлэх гэсэн зорилгодоо нийцүүлэн арга барилаа сонгох нь чухал билээ.

Түүнчлэн ардчилсан нийгэмд амьдарч буй хүн нь ардчиллын үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадах ёс суртахууны хүмүүжилтэй байх нь чухал. Ёс суртахууны ийм эгэл хэм хэмжээнд үзэл бодлоо илэрхийлэх, эрх, эрх чөлөөгөө эдлэх, хариуцлагаа ухамсарлах, шударга ёсыг хэрэгжүүлэх, ил тод байх, чөлөөтэй байх зэрэг багтана. Ийм эгэл хэм хэмжээг хэрэгжүүлдэг ёс суртахууныг Ж.Дьюи «рефлексив ёс суртахуун» гэж нэрлэжээ. Ж.Дьюигийн үзэж байгаагаар «Ёс суртахууны чанаруудаас хамгийн чухал нь үүрэг, хариуцлагаа ухамсарлах чанар» (Дэви<sup>8</sup>, 1915, хууд. 15) мөн. Энэ нь зөвхөн

суралцагч хүний хувьд биш, ерөөс нийгмийн гишүүний хувьд үүргээ ухамсарлах тухай асуудал юм. Тэрээр энэ тухай «Бие хүний хариуцлага, хувийн санаачилга бол ардчиллын интонаци» (Дьюи, 1994, хууд. 29) хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэ утгаар ардчилсан нийгэм дэх хүмүүжлийн үндсэн элемент бол суралцагч өөрийн зан үйлийн төлөө хүлээх хариуцлагаа ухамсарлах явдал юм. Философийн хичээлээр суралцагчдад рефлексив ёс суртахуун төлөвшүүлэхэд багийн ажил чухал үүрэгтэй. Багийн ажлууд нь бусдын өмнө үүрэг хүлээх, хариуцлага ухамсарлах, өөртөө шаардлага тавих, хамтын шийдвэрийг чухалчлахад сургадаг. Багш даалгаврыг сонголттойгоор санал болгож, тухайн сонгосон даалгаврыг амжилттай гүйцэтгэхэд нь туслан дэмжих замаар “унших-ярих-бичих-хамтрах-бүтээх” гэсэн таван үйлийг хичээлийн явцад хэрэгжүүлэн ажиллах нь дээр өгүүлсэн “хариуцлагаа ухамсарлах” чадварт суралцахад дэмжлэг болно. Мөн семинарын хичээл дээр ёс зүй, хүний философийн асуудлаар кейс шинжилгээ хийснээр суралцагчид ёс суртахууны мэдлэгтэй болохоос гадна ёс зүйн асуудлуудыг ялгаж, рациональ байдлаар ёс зүйн шийдвэрүүд гаргах, ёс зүйн зарчмуудыг ашиглах чадвартай болох ач холбогдолтой юм.

Философийн хичээлд ашиглаж болох сурах бичиг, гарын авлага

Хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлийн нэг чухал хэсэг нь сурах бичиг, гарын авлагыг шинэчлэх асуудал билээ. Багш төвтэй сургалтаас суралцагч төвтэй сургалтад шилжсэнтэй холбогдуулан өмнө нь хэрэглэж байсан сурах бичгүүд, гарын авлага үр дүнгээ өгөхөө больсон. Философийн хичээлийн хувьд дээрх өөрчлөлтийг хамгийн их анхаарвал зохилтой. Өөрөөр хэлбэл, 1990 оноос өмнө хэвлэгдэн гарсан сурах бичгүүдийг агуулга, арга зүй нь өнөөдрийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгатай нийцэхгүй тул сургалтдаа ашигладаг, оюутанд санал болгодог байдлыг өөрчлөх хэрэгтэй. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд нийцүүлэн философийн мэргэжлийн багш нар хамтран сурах бичиг, гарын авлага хэвлүүлж, сургалтад ашиглах шаардлага бий.

## Судалгааны үр дүн

Ийнхүү бид энэхүү өгүүлэлдээ төрийн өмчийн зарим их сургуулийн философийн хичээлийн хөтөлбөр дэх агуулгыг харьцуулж, холбогдох дүгнэлтийг хийсэн болно. Цаашид философийн хичээлийн хөтөлбөрийн тогтвортой агуулгыг тодорхойлох, уламжлалт арга зүйгээр

заах явдлыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага байна. Өөрөөр хэлбэл, зарим их, дээд сургуульд философийн түүхийг дэлгэрэнгүй үзэж байхад заримд нь философийг түүхчилж бус, асуудлаар нь судлуулах гэсэн ялгаатай хандлагууд байна. Бидний хувьд философийн түүхийг 2-4 цагт багтаан багцалж, үлдсэн цагт нь философийг асуудлаар (мэдлэг гэж юу болох, хүн гэж хэн болох, төр бар иргэний харилцаа, бурхан байдаг эсэх, байгаль ба нийгэм, сайн ба муу, сайхан ба муухай гэх зэрэг) судлуулбал илүү үр дүнтэй гэсэн байр суурийг илэрхийлэв. Ингэхдээ прагматик хандлагыг баримтлан оюутан нь тухайн хичээл дээр гүйцэтгэх даалгавраа сонгох, багаар ажиллах, хамтын шийдвэрт хүрэх, түүнийгээ хэрэгжүүлэх бүх бололцоог багшийн зүгээс олгоход анхаарах нь чухал байна.

## Дүгнэлт

Либерал арт нь олон янзын шинжлэх ухааныг хамарсан, олон шинжлэх ухааны зааг дээр оршдог судлах зүйл бүхий өргөн салбар юм. Либераль артсын боловсролыг чухалчилж буй өнөө үед бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээтэй мэргэжилтэн бэлтгэхэд философийн хичээлийг судлах нь зайлшгүй шаардлагатай юм. Монгол Улсад дээд боловсролын шинэчлэл хийгдэж байгаатай холбоотойгоор их, дээд сургуулиуд өөрийн онцлогтоо тохируулан суралцагчдын шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх чадвартай болгох зорилгоор прагматик хандлагыг баримтлан философийн хичээлийн хөтөлбөртөө өөрчлөлт оруулж байна. Бид философийн хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлт гэдэгт хичээлийн агуулгын өөрчлөлт, хичээлийг заах арга зүйг боловсронгуй болгох, багшийг хөгжүүлэх, сурах бичиг, гарын авлагыг шинэчлэх зэрэг асуудлыг багтааж үзлээ. Их, дээд сургуулиуд олон ургалч үзлийн үүднээс сургуулийн онцлогтоо тохируулан философийн хичээлийн хөтөлбөрийн агуулгаа шинэчилж байна. Гэхдээ хичээлийн шинэ агуулгыг хуучин аргаар заах нь үр дүн муутай байх болно. Иймд хичээлийн заах арга зүйд онцгойлон анхаарах шаардлагатай байна. Философийн хичээл дээр оюутнуудын шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор олон янзын даалгавруудыг гүйцэтгүүлэх боломж асар их байна. Өөрөөр хэлбэл, багш хөгжих, сэтгэлгээгээ өөрчлөх, сургалтын идэвхтэй аргуудаас суралцан, тэдгээрийг сургалтдаа бүтээлчээр хэрэглэж байгаа эсэхээс философийн хичээлийн чанар, үр дүн ихээхэн шалтгаалж байгааг энд онцлон тэмдэглэж байна. Монголын их, дээд сургуулиудын, ялангуяа

төрийн өмчийн их сургуулиудын философийн багш нар хамтран ажиллах, харилцан суралцах хэрэгцээ, шаардлага улам нэмэгдсээр байна.

#### Ашигласан материал

- Гомбосүрэн, Ц., Чулуунбаатар, Г. (2012). Өрнөдийн философийн асуудлаар Монголд явуулсан судалгаа, сурталчилгаа (1990-2012). Улаанбаатар
- Гомбосүрэн, Ц., Отгонбаяр, Б. (2010). Философи гэж юу болох талаарх томъёоллуудад хийсэн товч шинжилгээ. *Philosophy; Theory and practice. The international scientific conference*.
- БШУ-ны сайдын “Хичээлийн жагсаалт батлах тухай” А/285 тоот тушаал. Боловсрол Шинжлэх Ухааны Яам (2012)
- Лхам, И., Уянга, Г. (2017). Философийн үүрэг, ач холбогдлын талаарх Ж.Дьюингийн үзлийг эргэцүүлэхүй. “*Философи, эрхийн судлал*” сэтгүүл.
- Лхам, И., Уянга, Г. (2018). “Бүтээлч сэтгэхүй”. (Сэтгэлгээний түүх, соёл хичээлийн гарын авлага). Улаанбаатар: Тод бичиг
- Насанбат, Б. (2016). Ёс суртахууны боловсрол олгох сургалтын заах аргын асуудалд.

- “Монгол дахь ёс суртахууны тулгамдсан асуудал”. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл.
- Нямсүрэн, Ц. (2012). Философийн дасгал. Улаанбаатар: Талын цэнхэр салхи
- Орхон, Г. (2013). Их, дээд сургуульд заавал судлах «хэрэггүй» хичээлүүд. БШУЯ. Дээд боловсролын шинэчлэл төсөл. Улаанбаатар: БШУЯ
- Чулуунбаатар, Г. (1998). *Эрх чөлөө ба философи. Эрдэм шинжилгээний эмхэтгэл*, 57.
- Энхбаатар, А. (1998). *Эрх чөлөө ба философи. Эрдэм шинжилгээний эмхэтгэл*. 28-29.
- Дьюи, Д. (1994). Этика демократии. *Полис*, №3
- Дьюи, Д. (2003). *Реконструкция в философии. Проблемы человека*. Москва
- Dewey, J. (1897). *My Pedagogic Creed*. New York: Free press
- Dewey, J. (1915). *School and society*. Chicago: Chicago press
- Dewey, J. (1938). *Theory of the Moral Lif*. New York Richard Sigurdson. Why study the Liberal Arts? [Http://www.uni.edu/reineke/whystudyla.htm](http://www.uni.edu/reineke/whystudyla.htm), p.1.

#### К вопросу реформы программы занятий liberal arts во вузах (на примере занятия по философий)

И.Лхам, Г.Уянга

Сельскохозяйственный университет Монголии, Факультет экономики и бизнеса.  
Кафедра сельскохозяйственной и прикладной экономики

#### Аннотация

С 90-х годов XX века система высшего образования Монголии находилась в состоянии реформирования. Ныне в Монголии происходят реформа философского образования и переформатирование учебных программ философии. Философия в вузах призвана способствовать становлению личности, она должна побуждать к самопознанию и самосовершенствованию, обогащать и очищать человека духовно. *Философия*-это особая форма теоретико-познавательной *мыслительной деятельности* человека, направленная на всеобъемлющее *рациональное осмысление* мира и бытия человека в нём. Польза изучения философии состоит в развитии навыков критического и творческого мышления, что требуется как для формирования гражданских компетенций, необходимых человеку в демократическом обществе.

В статье обосновывается целесообразность преподавания философии в высших учебных заведениях, а также уделяется внимание особенностям ее преподавания. Авторы акцентируют внимание читателей на тех проблемах, с которыми сталкиваются преподаватели высшего учебного заведения. Статья призвана показать, что специфичность философии как учебной дисциплины требует не только совершенствования традиционных форм обучения, таких как лекция и семинар, но и поиска более эффективных форм проведения занятий. Авторы статьи, будучи преподавателями философии, предпринимают попытку ответить на три фундаментальных вопроса применительно к преподаванию философии: Что преподавать? Как преподавать? Зачем преподавать?.

#### Ключевые слова

Либераль артс, критическое и творческое мышление, прагматическая концепция